



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР**



Хүний амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ


2024 оны 4 дүгээр сарын байдлаар

Мөрөн сум

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 4 сарын байдлаар 659 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 95 тохиолдол буюу 12.6%-иар буурсан байна. Төрөлт Бүрэнтогтох, Жаргалант, Рэнчинлхэмбэ, Түнэл, Улаан-Уул, Цагаан-Уул, Цэцэрлэг, Хатгал сумдад өсч, бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 59,9% байна.




ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 4 сарын байдлаар нийт 659 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 97 тохиолдолоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 3.8 хувь /25/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 98,0 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2024 оны эхний 4 сард нийт 16172 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0,02 хувь нь туранхай, 0,1 хувь нь тураалтай, 0,1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 64,8 хувь нь Д амин дэм, 9,5 хувь нь олон найрлагат бичил тэжээл, А амин дэмийг 179 хүүхэд хэрэглэсэн байна.

НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 4 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 11 тохиолдол бүртгэгдсэн нь 2023 оны мөн үеэс 3 тохиолдлоор өсч, 1000 амьд төрөлтөнд 16,7 ногдож байна. Нийт 9 тохиолдол буюу 81,8 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд эндсэн хүүхдийн 6 нь эмэгтэй хүүхэд байна.


Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:



1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2024 оны эхний 4 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 6 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 2 тохиолдлоор өссөн байна. 1000 амьд төрөлтөнд 9,1 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл амьсгалын тогтолцооны эмгэг 3, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 3 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.





НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

2024 оны эхний 4 сарын байдлаар 248 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 18 тохиолдлоор өссөн байна. Нийт нас баралтын 19,4 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 41,7 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 26 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй адил, нийт нас баралтын 10,5 хувийг эзэлж, 10000 хүн амд 1,9 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 84 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 15 тохиолдлоор өсч, нийт нас баралтын 33,9 хувийг эзэлж, 10000 хүн амд 6,1 ногдож байна.

Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 7.2
2. Хавдар-6.1
3. Гадны шалтгаант өвчлөл- 1.9
4. Амьсгалын тогтолцооны өвчин-0.9
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-0.4
6. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-0.4



Осол гэмтлийн шалтгаант нас баралт, 2024 оны эхний 4 сарын байдлаар




Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 4 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 1093, эсийн шинжилгээ 2209 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 34 нас баралт буюу 47.1% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү 3 тохиолдол бүртгэгдсэн байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 15 тохиолдол байна.


АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 4 сарын байдлаар амбулаторид нийт 169894 үзлэг хийгдсэнээс 44.7 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 40.2 хувийг өвчний учир амбулаторид, 5.0 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 7.7 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 2.5 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.

Амбулаторийн үзлэгийн төрөл



Амбулаторийн үзлэг, 2023-2024 оны эхний 4 сарын байдлаар



ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 557 жирэмсэн эмэгтэйчүүдээс 92,6 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 91.2 хувь нь хамрагдаж, 1.6 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 4 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 90.1 хувийг, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 94,8 хувийг, ХДХВ илрүүлэх шинжилгээнд 94,3 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-4 трихомониаз-7, тэмбүү-13 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2024 оны эхний 4 сарын байдлаар халдварт бус өвчлөл 32930 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 29180 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 2399,2 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 412 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1.3 хувийг эзэлж, 10000 хүн амд 30,1 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 537.8
2. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-452.2
3. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 430.0
4. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-209.9
5. Нүд ба түүний дайврын өвчин-195.2



Стационарт нийт 10905 хүн хэвтэж эмчлүүлж, 72962 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 6.7, орны эргэлт 10.9, орны фонд ашиглалт 72.9 фонд ашиглалтын хувь 66.3 байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 4 сарын байдлаар нийт 7294 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэснээс 13.7 хувь /998/ нь алсын дуудлага, 1.9 хувь /139/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 60.8 дуудлага, АНЭ 17.8 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.

ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны эхний 4 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 17448 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 20.0 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 42.4% эрэгтэй, 57.6% нь эмэгтэй байна.

Давтан үзлэгт 353 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 65 буюу 18.4% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 12981 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 24.1 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 40.2% эрэгтэй, 59.8% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 57 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 3 буюу 5.3% нь онош баталгаажсан байна.



ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 72991 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 66.6 хувь
- Өвчний учир үзлэг 11.0 хувь
- Диспансерийн хяналт 5.4 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 16.6 хувь
- Гэрийн дуудлага 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 1360 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 11.0 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.1 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 205 жирэмсэн эмэгтэйгээс 90.7 хувийг эрт үед нь хяналтанд авч 91.2 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 83 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 19 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 40, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 3 тохиолдол эндсэн байна.

ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 12878 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 10.2 хувь
- Диспансерийн хяналт 3.7 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 0.02 хувь
- Гэрийн дуудлагаар 0.02 хувь
- Өвчний учир үзлэг 86.1 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 3167 хүн хэвтэн эмчлэгдэж, 22795 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.2 орны эргэлт 10.5 ба орны фонд ашиглалт 75.2, орны фонд ашиглалтын хувь 68.4 байна.

Нийт халдварт бус өвчний 331 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 313 тохиолдол бүртгэгдсэн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН

Аймгийн хэмжээнд эхний 4 сарын байдлаар 438 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 31.9 ногдож байна. 2023 оны мөн үед 436 тохиолдол, 10000 хүн амд 31.9 ногдож байжээ.

10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Баянзүрх /34.6/ Бүрэнтогтох /34.1/, Тосонцэнгэл /45.1/, Цэцэрлэг /54.4/, Мөрөн /53.2/ суманд аймгийн дунджаас өндөр байна.


Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 50.2 хувь, сүрьеэ 2,5 хувь, амьсгалын замын өвчин 42.2 хувь, гэдэсний халдварт өвчин 4.9 хувь, арьс салтстаар халдварлах халдвар 0,2 хувийг тус тус эзэлж байна.

ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт цочмог халдварт өвчний 218 тохиолдлоос:

- Сальмонеллэз 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хоолны хордлого 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 45 тохиолдлоор

- Хепатит В 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор
- Хепатит С 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Сүрьеэ 11 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор
- Ёлом 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Хачигт рикеттиоз 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Гар хөл амны өвчин 6 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор
- Ковид-19 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор тус тус буурч
- Цусан суулга 20 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор
- Гахайн хавдар 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Салхинцэцэг 178 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 130 тохиолдлоор тус тус өсч өмнөх оны үетэй адил тохиолдол байна.
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.




ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ

1. 2024 оны эхний 4 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 215 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс цэврүүт тууралт 81.4 хувь (175), цочмог халууралт тууралтат 7.9 хувь (17), цочмог цусархаг тууралтат 8.8 хувь (19), цочмог усархаг 0.5 хувь (1), цочмог шарлалттай 0.5 хувь (1), гахай хавдар 0.5 хувь (1), хоолны хордлогот халдвар 0.5 хувь (1) тус тус бүртгэгдсэн байна.
2. Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/



Халдварт өвчний хамшинж, сэжигтэй нийт тохиолдол, бүртгэгдсэн долоо хоногоор




| Тохиолдлын нэр | 2023 он | | 2024 он | |
|--------------------------|-----------|-----------------|-----------|-----------------|
| | бодит тоо | дүнд эзлэх хувь | бодит тоо | дүнд эзлэх хувь |
| Халууралт тууралт | 18 | 12.7 | 17 | 7.9 |
| Цэврүүт тууралт | 54 | 38.0 | 175 | 81.4 |
| Цусархаг суулгалт | 12 | 8.5 | 19 | 8.8 |
| Усархаг суулгалт | 6 | 4.2 | 1 | 0.5 |
| Цочмог шарлалт | 6 | 4.2 | 1 | 0.5 |
| Гахайн хавдар | 0 | 0.0 | 1 | 0.5 |
| Хоолны хордлогот халдвар | 46 | 32.4 | 1 | 0.5 |
| Нийт | 142 | 100.0 | 215 | 100.0 |


ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН

2024 оны эхний 4 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 5936 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 430,8 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 4465 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 326,3 болсон байна.


Томуу, томуу төст өвчин, 10 000 хүн амд




Томуу, томуу төст өвчин 10000 хүн амд, сумдаар



Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар)




АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар)



БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 50.2% (220) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 64.0% (279) тохиолдол бүртгэгдсэнээс:

- Тэмбүү 62 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Трихомониаз 19 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор тус тус өсч
- Гонококкт халдвар 140 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 71 тохиолдлоор өссөн байна.



ХЯНАСАН:
 ДҮГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
 М.ҮҮРИЙНБАЯР
 ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН
 МЭРГЭЖИЛТЭН П.БАЯРМАА